СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.02.23 № 57
танай ________ -ны№ __________ -т

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БАДРАХЦОГ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Мэргэжлийн хяналтын газрар бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсантай холбоотой тус газарт барилга, граш, газар болон бусад үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн данс бүртгэлд орлого авч, зарим хөрөнгийг акталж данснаас хасчээ.

## Аудитын гол асуудал

Барилга ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нэмэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт “Хангалттай” үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА

D:/Bichig hereg/2024/A4 toot

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2024/14/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2024 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: Г.Даваа<br>Утас: 70518396<br>Аудитын менежер: М.Нарантуяа<br>Утас: 70512123<br>Аудитор: Б.Ганцэцэг<br>Утас: 70512123 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа........ 11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........ 12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14
**4.1 Ерөнхий зүйл** ........ 14
**4.2 Материаллаг байдал** ........ 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 15
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд** ........ 15
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 15
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 15
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 15
Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй. ........ 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.02.23 № 57
танай ________ - ны№ ________ -т

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БАДРАХЦОГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Мэргэжлийн хяналтын газрар бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсантай холбоотой тус газарт барилга, граш, газар болон бусад үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн данс бүртгэлд орлого авч, зарим хөрөнгийг акталж данснаас хасчээ.

**Аудитын гол асуудал**

Барилга ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нэмэгдсэн байна.

D:/Bichig hereg/2024/A4 toot

**Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт "Хангалттай" үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА

D:/Bichig hereg/2024/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,581,161.00** | **26,248,510.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 52,000.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 52,000.00 | 00.00 |
| **3121** | **Төгрөг** | 52,000.00 | 00.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 52,000.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 19,952,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 19,952,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 19,952,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,577,161.00 | 26,248,510.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 7,300,821.00 | 8,063,910.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,300,821.00 | 8,063,910.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 5,491,400.00 | 7,302,400.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,784,940.00 | 10,882,200.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,538,540.00 | 5,481,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,957,400.00 | 4,105,400.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 289,000.00 | 295,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **149,171,615.61** | **335,425,514.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 149,171,615.61 | 335,425,514.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 137,519,615.61 | 221,048,514.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 20,852,370.00 | 112,393,964.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -3,336,379.20 | -31,065,083.82 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 184,733,258.00 | 212,081,276.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -65,933,011.36 | -94,476,542.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,243,130.00 | 36,269,930.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,039,751.83 | -14,155,030.08 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,652,000.00 | 114,377,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,652,000.00 | 114,377,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **189,752,776.61** | **361,674,024.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **52,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 52,000.00 | 00.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 52,000.00 | 00.00 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 52,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **189,700,776.61** | **361,674,024.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 189,700,776.61 | 361,674,024.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,652,000.00 | 11,652,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 11,652,000.00 | 11,652,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 166,125,354.71 | 338,098,602.22 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 166,125,354.71 | 166,125,354.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 171,973,247.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,923,421.90 | 11,923,421.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **189,752,776.61** | **361,674,024.12** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **420,419,306.53** | **951,789,962.47** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,549,906.53** | **243,303,062.47** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,549,906.53 | 243,303,062.47 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан- Үндсэн хөрөнгө | 00.00 | 230,846,092.67 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан- Бараа материал | 00.00 | 12,456,969.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,549,906.53 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 16,549,906.53 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,869,400.00** | **708,486,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 399,961,000.00 | 704,008,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 399,961,000.00 | 704,008,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,908,400.00 | 4,478,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,908,400.00 | 4,478,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **439,255,251.84** | **760,363,514.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **439,255,251.84** | **760,363,514.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 437,206,222.34 | 758,705,571.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 308,276,300.00 | 564,234,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 242,575,541.15 | 360,942,156.39 |
| 210102 | Нэмэгдэл | 57,380,783.39 | 142,947,886.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,303,000.00 | 47,192,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 13,152,256.70 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,016,975.46 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,611,160.50 | 88,891,799.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,220,204.74 | 63,942,399.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,097,739.08 | 9,087,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,478,191.29 | 4,229,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 619,548.04 | 1,057,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,195,477.35 | 10,574,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,728,130.00 | 18,144,330.12 |
| 210302 | Түлш, халаалт | 7,265,670.00 | 15,417,929.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 264,160.00 | 360,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,276,600.00 | 12,335,017.18 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 6,714,900.00 | 7,981,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,301,000.00 | 2,120,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,770,300.00 | 1,480,227.18 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,338,400.00 | 753,250.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 102,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,141,100.00 | 4,458,950.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 330,000.00 | 520,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 557,000.00 | 900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,254,100.00 | 3,038,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,123,078.00 | 18,671,680.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,470,980.00 | 4,608,970.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 4,000,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 6,652,098.00 | 10,062,710.80 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,049,853.84 | 51,969,494.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,908,400.00 | 4,478,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 350,000.00 | 250,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,791,453.84 | 47,240,994.17 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,049,029.50 | 1,657,943.70 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 350,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000.00 | 1,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,699,029.50 | 157,943.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,699,029.50 | 157,943.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-18,835,945.31** | **191,426,447.50** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 6,500,000.00 | 19,453,199.99 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 6,500,000.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -6,500,000.00 | -19,453,199.99 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-25,335,945.31** | **171,973,247.51** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **507,451,091.98** | **833,950,991.81** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **103,581,691.98** | **125,464,091.81** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 103,581,691.98 | 125,464,091.81 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 103,581,691.98 | 125,464,091.81 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,581,691.98 | 125,464,091.81 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,869,400.00** | **708,486,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 399,961,000.00 | 704,008,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 399,961,000.00 | 704,008,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,908,400.00 | 4,478,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,908,400.00 | 4,478,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **506,249,091.98** | **834,002,991.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **506,249,091.98** | **834,002,991.81** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **400,670,370.50** | **706,828,956.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 308,276,300.00 | 564,234,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 242,575,541.15 | 360,942,156.39 |
| 210102 | Нэмэгдэл | 57,380,783.39 | 142,947,886.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,303,000.00 | 47,192,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 13,152,256.70 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,016,975.46 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,611,160.50 | 88,891,799.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,220,204.74 | 63,942,399.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,097,739.08 | 9,087,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,478,191.29 | 4,229,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 619,548.04 | 1,057,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,195,477.35 | 10,574,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,728,130.00 | 18,144,330.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 868,000.00 | 2,366,400.72 |
| 210302 | Түлш, халаалт | 7,265,670.00 | 15,417,929.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 264,160.00 | 360,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,330,300.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,082,300.00 | 15,192,077.18 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,109,000.00 | 10,904,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,301,000.00 | 2,120,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,770,300.00 | 1,580,227.18 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 852,000.00 | 587,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,243,100.00 | 6,716,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 450,000.00 | 2,496,000.00 |
| 210602 | Тавилга | 19,952,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 587,000.00 | 720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,254,100.00 | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,470,980.00 | 8,921,950.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,001,980.00 | 4,921,950.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 469,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 4,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,258,400.00 | 4,728,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,908,400.00 | 4,478,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 350,000.00 | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **105,578,721.48** | **127,174,035.51** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 350,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000.00 | 1,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 105,228,721.48 | 125,674,035.51 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,793,049.50 | 235,394.17 |
| 213306 | Төвлөрүүлэх шилжүүлэг / Улсын төсөв/ | 103435671.98 | 125,438,641.34 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,202,000.00** | **-52,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,150,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,150,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,150,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,150,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,150,000.00** | **00.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 52,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 52,000.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 11,652,000.00 | 11,923,421.90 | 50,307,379.23 | 00.00 | 73,882,801.13 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 7,696,738.49 | 00.00 | 7,696,738.49 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,652,000.00** | **11,923,421.90** | **58,004,117.72** | **00.00** | 81,579,539.62 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -4,622,112.76 | 00.00 | -4,622,112.76 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,652,000.00** | **11,923,421.90** | **166,125,354.71** | **00.00** | 189,700,776.61 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,652,000.00** | **11,923,421.90** | **166,125,354.71** | **00.00** | 189,700,776.61 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,652,000.00** | **11,923,421.90** | **166,125,354.71** | **00.00** | 189,700,776.61 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 171,914,997.53 | 00.00 | 171,914,997.53 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,652,000.00** | **11,923,421.90** | **338,040,352.24** | **00.00** | 361,615,774.14 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 704,008,400.00 | 703,850,456.30 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 704,008,400.00 | 703,850,456.30 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 702,508,400.00 | 702,350,456.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 564,234,300.00 | 564,234,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 411,198,900.00 | 360,942,156.39 |
| 210102 | Нэмэгдэл | 112,251,400.00 | 142,947,886.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,784,000.00 | 47,192,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,000,000.00 | 13,152,256.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,891,800.00 | 88,891,799.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,942,400.00 | 63,942,399.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,087,300.00 | 9,087,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,229,900.00 | 4,229,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,057,500.00 | 1,057,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,574,700.00 | 10,574,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,170,300.00 | 18,144,330.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,180,500.00 | 2,366,400.72 |
| 210302 | Түлш, халаалт | 15,349,900.00 | 15,417,929.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 347,200.00 | 360,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 292,700.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,246,000.00 | 15,192,077.18 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,100,000.00 | 10,904,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,850,000.00 | 2,120,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,580,227.18 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 796,000.00 | 587,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,716,000.00 | 6,716,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,496,000.00 | 2,496,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 720,000.00 | 720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,000,000.00 | 8,921,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.00 | 4,921,950.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 250000.00 | 250000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 250,000.00 | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1500000.00 | 1500000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 704,008,400.00 | 703,850,456.30 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 704,008,400.00 | 703,850,456.30 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 704,008,400.00 | 703,850,456.30 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 28.00 | 28.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22.00 | 22.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **4,478,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **4,478,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 4,478,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 4,478,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 4,478,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 4,478,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 4,478,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4,478,500.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс "Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх, Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулахад оршино" эрхэм зорилгын хүрээнд иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа нь Иргэний бүртгэлийн тухай хууль, МУИХ-ын сонгуулийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хууль зэрэг хууль, эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 171.8 сая төгрөгөөр буюу 90.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 52.0 | 0 | (52.0) |
| Авлага | 19,952.0 | 0.00 | (19,952.00) |
| Бараа материал | 20,577.16 | 26,248.51 | 5,671.35 |
| Үндсэн хөрөнгө | 149,171.61 | 335,367.26 | 186,195.65 |
| **Нийт хөрөнгө** | **189,752.77** | **361,615.77** | **171,863.00** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Хуримтлагдсан үр дүн | 189,700.77 | 361,615.77 | 171,915.00 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /Өмчийн дүн/** | **189,700.77** | **361,615.77** | **171,915.00** |

- *Авлага данс буурсан нь Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 2022 онд 21 аймагт нэгдсэн журмаар архивын нягтруулгын шүүгээг 2023 оны 1-р улиралд гүйцэтгэж дуусахаар гэрээ байгуулж, тайланд хугацаанд хөрөнгийг хүлээн авсан байна.*
- *Бараа материал данс 5,671.3 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь УБЕГ-аас нийлүүлсэн принтерийн хорны үлдэгдэл дийлэнх хувийг эзэлж байна. УБХ нь тусгай зориулалтын принтерийн хор хэрэглэдэг учир дансны үлдэгдэлд нөлөөлжээ.*
- *Үндсэн хөрөнгө данс 186,195.6 мянган төгрөгөөр өссөн нь МХГ татан буугдсантай холбоотой тухайн байгууллагад газар, граш, барилга шилжиж ирсэн , мөн УБЕГ-аас киоск машин, компьютер шилжин ирсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 846.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 199.9 сая төгрөгөөр бууруулж 646.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь албан томилолт, урсгал засвар, ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан тансан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 57.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 704.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 140.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 703.8 сая төгрөгийн зардал гарч 0.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 703.8 сая төгрөг буюу 99.9 хувьтай зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70406 80101- Үндсэн үйл ажиллагаа | 704,008.4 | 703,850.4 | 157.9 | 99.9% |
| 2 | 70406 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг | 1,500.0 | 1,500.0 | 0 | 100% |
| | **НИЙТ** | **705,508.4** | **705,350.4** | **157.9** | **100%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар УБЕГ-аас сонгууль зохион байгуулахтай холбоотой Уулбаян сумын ИТХ-ын нөхөн сонгуулийн зардалд нийт 4.5 сая төгрөгийн санхүүжилт авч 100 хувь үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл бараа үйлчилгээний бусад зардалд 4.5 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

### *3.5.5* Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улсын бүртгэлийн хэлтэс нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Нарантуяа, дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 760.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь албан томилолтын зардал болон БҮТЭЗ-ийн зардал зэргийг хасаж баталсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 2023.05.30-ны өдрийн 234 тоот албан бичгээр ирүүлж, биелэлтийг хангасан байна.

*Хүснэгт 4.* Зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 0 | 3 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **0** | **3** | **0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 алдаа зөрчил илэрснээс, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 0.7 сая төгрөгийн 1 алдаа зөрчил илэрхийлснийг залруулсан.

**5.1 Зөвлөмж**

***1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

*Балансаас балансад шилжиж ирсэн барилгын салшгүй хэсэг болох газар нь татан буугдсан Мэргэжлийн хяналтын газрын нэр дээр байгаа тул газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авах шаардлага үүссэн байна.*

*Өгсөн зөвлөмж:*

*Барилгын салшгүй хэсэг болсон газрыг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Газрар эзэмших гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэх | 1 | 0 | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 |